

**Тэнгэрлиг Медиа Групп ХК**

**2021**

**ХАГАС ЖИЛИЙН ТАЙЛАН**

Хүчтэй. Хамтдаа.



## Агуулга

1.	Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан	4
1.1	Үйл ажиллагаа	4
1.2	Төлөөлөн удирдах зөвлөл	4
1.3	Гүйцэтгэх захирал	8
1.4	Хувьцаа эзэмшигчид	8
2	Компанийн хагас жилийн санхүүгийн тайлан	9

## 1. Компанийн хагас жилийн үйл ажиллагааны тайлан

### 1.1 ҮЙЛ АЖИЛЛАГАА

Тэнгэрлиг Медиа Групп ХК (цаашид “Тэнгэрлиг Медиа Групп” гэх) нь Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй Е-Моние ХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан компани юм. Е-Моние ХК (одоогийн Тэнгэрлиг Медиа Групп) нь 2017 оноос хойш үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд 2021 онд нэр бүхий хувьцаа эзэмшигчид хувьцаагаа зарах санал гаргасны дагуу Ард Менежмент ҮЦК ХХК нь тус компанийн 90.4%-ийг худалдан авснаар үйл ажиллагааг нь өргөжүүлэн ажиллахаар шийдвэрлэсэн билээ.

2021 оны 4 сарын 30-ны өдөр Е-Моние ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал болж, компанийн оноосон нэрийг Тэнгэрлиг Медиа Групп ХК болгон өөрчилж, Монгол Улс төдийгүй Олон улсад медиа чиглэлээр үйл ажиллагаа явуулахаар түүхэн шийдвэр гаргасан. Үүний дагуу Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2021 оны 6 сарын 7-ны өдөр 148 тоот тушаалаар компанийн оноосон нэрийг өөрчлөхийг зөвшөөрсөн болно.

Тэнгэрлиг Медиа Групп ХК нь Монгол улсын хэвлэл мэдээллийн салбарын анхны олон нийтийн нээлттэй хувьцаат компани болох, санхүүжилтийн хувьд хараат бус байх, мөн орчин үеийн технологийн дэвшлийг ашиглаж шилдэг контент бүтээх, хэвлэлийн салбарт шинэ жишиг тогтоож эерэг мэдээлэл олон нийтэд түгээх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна.

### 1.2 ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ

2021 оны 4 сарын 30-ны өдөр Тэнгэрлиг Медиа Групп ХК -ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компани нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдээ сонгосон. Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид ТУЗ гэх) нь 9 гишүүний бүрэлдэхүүнтэй бөгөөд медиа салбарт олон жил ажилласан туршлагатай мэргэжлийн чадварлаг баг болно. Шинээр сонгогдсон ТУЗ-ийн гишүүд хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийг удирдлагаар хангаж, стратеги хэтийн төлөвийг тодорхойлох, хувьцаа эзэмшигчдийн гаргасан шийдвэрийг хэрэгжүүлж ажиллана.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдсанаас хойш ТУЗ нь нийт 2 удаа хуралдаж, компанийн үүсгэн байгуулах бичиг баримтад өөрчлөлт оруулах, ТУЗ-ийн даргыг сонгох, нэмж хувьцаа гаргах, гүйцэтгэх захирлыг томилох, медиа салбарт хөрөнгө оруулалт хийхтэй холбоотой хэлэлцээр хийх зэргээр компанийн үйл ажиллагаа хэвийн явуулах бэлтгэл ажлуудыг хангаж эхэлсэн билээ.



**Галням Уянга**

### **Боловсролын байдал**

- Хартфорт дээд сургууль
- Төв Хятадын Хэл Судлалын Их Сургууль
- Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Банк санхүү

### **Ажилласан байдал**

- 2021 ТэнгэрЛиг Медиа Групп, ТУЗ-ийн дарга
- 2019 Ард Пропертиз ХХК, Гүйцэтгэх захирал
- 2009 Арван гэрийн холбоо ХХК, Гүйцэтгэх захирал
- 2005 Грасрүүтс жижиг дунд бизнес дэмжих төв (НҮБ-ийн төсөл), Захирал



**Ганхуяг Бат-Эрдэнэ**

### **Боловсролын байдал**

- Зүүн Англия, Норвичийн Их Сургууль-ИБУИНВУ, Улс төр, нийгэм судлал
- Харвард Бизнесийн Сургууль, Удирдах албан тушаалтны хөтөлбөр

### **Ажилласан байдал**

- 2006 Гацуурт ХХК, Гадаад харилцааны ахлах менежер
- 2009 Монголын Чөлөөт Бөхийн Холбоо, Ерөнхий Нарийн Бичгийн Дарга
- 2009 Номсис ХХК, Ерөнхий захирал
- 2011 Монгол Телевиз ХХК, Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал
- 2018 Монгол Телевизүүдийн Холбоо, Удирдах Зөвлөлийн дарга
- 2021 Монгол Телевиз ХХК, Гүйцэтгэх захирал



**Цолмон Бархас**

### **Боловсролын байдал**

- Санхүү Эдийн Засгийн Дээд Сургууль, Бизнесийн эдийн засагч
- Виржиниагийн Олон Улсын Их Сургууль, Бизнесийн удирдлага

### **Ажилласан байдал**

- 2021 Ард Холдингс Интернэшл ХХК, Гүйцэтгэх захирал
- 2018 Таван Богд Хот Пот, Ерөнхий инженер
- 2017 Таван Богд Фүүдс Пицца, Маркетингийн албаны дарга
- 2016 Таван Богд Трейд ХХК, Бизнес хөгжүүлэлтийн ахлах менежер
- 2015 Голомт банк,
  - » Бүс хариуцсан менежер
  - » Гүйцэтгэх захирлын нарийн бичгийн дарга
  - » Байгууллагын банкны менежер



**Өнөрбаян Ашүү**

**Боловсролын байдал**

- Будапештийн ЭЛТЭ ИС, Эрх зүйч
- Отгонтэнгэр Их Сургууль, Аж ахуйн эрх зүйч

**Ажилласан байдал**

- 2018 Ард Менежмент ҮЦК ХХК, Хуулийн зөвлөх
- 2015 Номын Хишиг ХХК, Гүйцэтгэх захирал
- 2009 Блюскай Партнэрс ХХК, Зөвлөх, Гүйцэтгэх захирал
- 2006 Монгол улс дахь Унгар Улсын Өргөмжит консулын Газар, Өргөмжит консулын коллег
- 2004 УИХ-ын Тамгын Газар, УИХ-ын гишүүний туслах



**Батсайхан Батзаяа**

**Боловсролын байдал**

- Шинжлэх Ухаан Технологийн Их Сургууль-МХТС, Мэдээллийн технологи
- IOWA State University, Human Computer Interaction

**Ажилласан байдал**

- 2020 Ворлд Плас Дижитал ХХК, Гүйцэтгэх захирал
- 2015 Анрид ХХК,
  - » Хамтран байгуулагч
  - » Гүйцэтгэх захирал
- 2014 Бату Дижитал ХХК,
  - » Хамтран байгуулагч
  - » Гүйцэтгэх захирал
- 2010 The New Media Marketing Agency, Технологи Хариуцсан захирал



**Амарсайхан Ундрал**

**Боловсролын байдал**

- Монгол Улсын Их Сургууль, Эдийн засаг
- Львений Их Сургууль-Бельгийн Вант Улс /KU Leuven/, Менежмент

**Ажилласан байдал**

- 2017 Монголын Үндэсний Олимпын Хороо, Ерөнхий нарийн бичгийн даргын орлогч
- 2015 Анрид ХХК,
  - » Үүсгэн байгуулагч
  - » Гүйцэтгэх захирал
- 2008 UBS Телевиз,
  - » Сэтгүүлч
- Редактор



**Нацагдорж Цогт**

**Боловсролын байдал**

- Москва АХДС
- Хамлын Их Сургууль

**Ажилласан байдал**

- 2006 Бона лекс хуулийн товчоо, Хуульч захирал
- 1999 Хууль Зүйн Дотоод Хэргийн Яам, Ахлах Мэргэжилтэн
- 1994 Үндэсний Хөгжлийн Газар, Мэргэжилтэн



**Хасаг Эрдэнэбаяр**

**Боловсролын байдал**

- Монгол Улсын Боловсролын Их Сургууль
- London Metropolitan University, Fine-Art

**Ажилласан байдал**

- 2019 Ворлд Плас Дижитал ХХК, Захирал-Үүсгэн байгуулагч
- 2017 Вүүвүү ХХК,
  - » Захирал
  - » Үүсгэн байгуулагч
- 2014 Анлимитэд Айдеа ХХК,
  - » Захирал
  - » Үүсгэн байгуулагч



**Ванчиг Ганзориг**

**Боловсролын байдал**

- Худалдаа Үйлдвэрлэлийн Дээд Сургууль, Бизнесийн удирдлага
- Австралийн Нотр Дэймийн Их Сургууль, Бизнесийн удирдлага
- Японы Олон Улсын Их Сургууль, Цахим бизнесийн удирдлага

**Ажилласан байдал**

- 2015 BSP, Удирдах Зөвлөлийн дарга
- 2013 Медиа Групп, Гүйцэтгэх захирал
- 2010 Шунхлай Групп, Стратеги хариуцсан захирал

### 1.3 ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Компани нь хэвлэл мэдээллийн салбарт үйл ажиллагаа явуулахаар зорьж байгаатай холбоотойгоор ТУЗ-өөс гүйцэтгэх захирлыг өөрчилж, Г.Бат-Эрдэнийг гүйцэтгэх удирдлагаар томилсон болно. Г.Бат-Эрдэнэ нь 2000 онд Өсвөрийн Зохион Бүтээгчдийн дунд сургууль, 2004 онд Зүүн Английн Их Сургуулийг Улс төр, нийгэм судлалаар суралцаж төгссөн. Тэрээр 2009 онд Монголын Чөлөөт Бөхийн Холбооны ерөнхий нарийн бичгийн даргаар, 2010 онд Номсис ХХК-ийн үүсгэн байгуулагч, ерөнхий захирал, 2012 онд Монгол телевизийн Стратеги бодлого төлөвлөлт хариуцсан дэд захирал, 2018 оноос Монголын телевизүүдийн холбооны УЗДаргаар, 2021 оноос Монгол телевизийн гүйцэтгэх захирлаар томилогдон тус тус ажиллаж байна. Мөн тэрээр киноны тухай хуулийг боловсруулах ажлын хэсэгт орж, хуулийн төслийг өргөн барихаар ажиллаж байна.

### 1.4 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

2021 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар компани нь нийт 126 хувьцаа эзэмшигчидтэй байна.

Хувьцаа эзэмшигчдийн бүтэц /2021.06.30/

Нэр	Тоо ширхэг	Хувь
Ард Менежмент ҮЦК ХХК	52,925	90%
Бусад 125 хувьцаа эзэмшигчид	5,618	10%
Нийт	58,543	100%



## 2. КОМПАНИЙН ХАГАС ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Санхүү байдлын тайлан

ТэнГэрЛиг Медиа Групп ХК нь 2021 оны эхний хагас жилийн байдлаар 6.9 сая төгрөгийн хөрөнгөтэй, 5.5 сая төгрөгийн өр төлбөртэй байна.

	/сая төгрөг/	
	2020	2021 Q2
	Аудит	Урьдчилсан
<b>НИЙТ ХӨРӨНГӨ</b>	<b>6.9</b>	<b>6.9</b>
Эргэлтийн хөрөнгө	1.9	1.9
Эргэлтийн бус хөрөнгө	5.0	5.0
<b>ӨР ТӨЛБӨР</b>	<b>5.5</b>	<b>5.5</b>
Богино хугацаат өр төлбөр	0	0
Урт хугацаат өр төлбөр	5.5	5.5
<b>ЭЗДИЙН ӨМЧ</b>	<b>1.4</b>	<b>1.4</b>
Өмч	5.0	5.0
Хуримтлагдсан ашиг	-3.6	-3.6
<b>ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН</b>	<b>6.9</b>	<b>6.9</b>

Орлогын тайлан

	/сая төгрөг/	
	2020	2021 Q2
	Аудит	Урьдчилсан
<b>ОРЛОГО</b>	-	-
<b>ЗАРДАЛ</b>	-	-
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-	-
Орлогын татварын зардал	-	-
<b>ОРЛОГЫН НИЙТ ДҮН</b>	-	-

